



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 09 сарын 20 өдөр

Дугаар А/48

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолийн хавсралтаар баталсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр”-ын гуравдугаар зорилт, Хотын стандарт, хяналтын газрын Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2023 оны хөтөлбөр, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, Монгол бичгээр баримт бичиг төлөвлөх, боловсруулах, цахим орчинд хэрэглээг нэвтрүүлэх зорилготой Монгол бичгийн дунд шатны сургалт болон Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартын дотоод аудитор бэлтгэх сургалтад хавсралтад нэр дурьдсан 13 албан хаагчийг 2023 оны 9, 10 дугаар сард хамруулсугай.

2. Дээрх сургалтад шаардагдах 1,600,000 (Нэг сая зургаан зуун мянга) төгрөгийг Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас гаргаж олгохыг Ахлах нягтлан бодогч (Б.Түмэнжин)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Э.Даваахатан)-т даалгасугай.

ДАРГА

С.ТӨМӨРДУЛАМ

